



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

┌ Аудитын тайланг баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23 дугаар зүйлийн 2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2015 оны 5 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайдад зөвлөсүгэй.
5. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга С.Төмөрхүүд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Монгол Улсын Ерөнхий аудиторын
 2013 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн
 187 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт



Монгол Улсын 2013 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тавигдсан төлбөрийн актын жагсаалт

УХА0122

№	Төлбөр хариуцагчийн		Төлбөр зөрчлийн товч утга	Актын дугаар	Төлбөрийн дүн
	Нэр	Албан тушаал			
1	Г.Батдорж	Хөтөлийн цемент шохой үйлдвэрийн захирал	Ногдол ашгийн орлого 998.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй	01/27	998.6
	М.Амартүвшин	Ерөнхий нягтлан бодогч			
2	Ч.Насанбат	ГЕГ-ын санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	Гаалийн бүрдүүлэлтийн "түр горим"-ын дансанд байршиж буй барьцаа хөрөнгийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдөр тооцогдсон хүү 42.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй	01/26	42.3
	П.Энх-Оюун	Нягтлан бодогч			
Нийт дүн					1,040.9

(сая төгрөгөөр)